



ҮАГ-ын 2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

2006 оны 2 дугаар сар

**ИНЕГ-ААС ТӨЛСӨН ЗЭЭЛ,
ЗЭЭЛИЙН ХҮҮГ ТУСГАЙ
ДАНСАНД
ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА**

**ИНЕГ, СЭЗЯ-ны хооронд байгуулсан
дамжуулан зээлдүүлэх 1256 MON (SF),
1370 MON (SF) гэрээний биелэлт**

УЛААНБААТАР ХОТ

Агуулга

Ерөнхий зүйл	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
	Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд	4
	Аудитын стандартын талаархи мэдэгдэл	4
Аудитын дүн	Авсан болон төлсөн зээлийн хөрөнгийн тооцоо, бүртгэл хөтлөлт	5
	Зээл төлөх орлого бүрдүүлсэн байдал	8
	ИНЕГ-аас хэрэгжүүлсэн төслийн үр дүн	9
Дүгнэлт		12
Холбогдох байгууллагын санал		13
Зөвлөмж		14
Хавсралт		15

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Иргэний нисэхийн ерөнхий газар /ИНЕГ/ ба СЭЗЯ /хуучин нэрээр/-ны хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх 1256 MON (SF), 1376 MON (SF) гэрээний биелэлтэд Сангийн сайдын хүсэлтийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аудит хийв.

Дараахь асуудлыг шалгаж дүгнэлт гаргахад энэхүү аудитын зорилт оршиж байв. Үүнд:

1. Дамжуулан зээлдүүлэх гэрээний 2, 4 дүгээр зүйлд заасны дагуу авсан болон төлсөн зээлийн хөрөнгийн тооцоо, түүнийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал
2. Дамжуулан зээлдүүлэх гэрээний 4 дүгээр зүйлийн 5-д заасны дагуу зээл төлөх орлого бүрдүүлсэн байдал
3. Дамжуулан зээлдүүлэх гэрээний 6 дугаар зүйлд заасны дагуу ИНЕГ-аас хэрэгжүүлсэн төслийн үр дүн

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглан Сангийн яам, ИНЕГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийн, тэднээс асуулга, лавлагаа авч, холбогдох мэдээллийг харьцуулах, байгууллагын санхүүгийн болон ажлын тайланг судлан, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулан нөхцөл байдлын шинжилгээ хийлээ.

Ерөнхий зүйл

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Дараахь хууль тогтоомжийг энэхүү аудитад шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр худалдан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмын тухай хууль
- ИНЕГ, СЭЗЯ-ны хооронд байгуулсан 1256 MON (SF), 1370 MON (SF) дамжуулан зээлдүүлэх гэрээ
- Зам, тээвэр, аялал жуучлалын яам /ЗТАЖЯ/, Сангийн яамнаас хянаж баталсан төсөв
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг баримталсан бөгөөд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав.

Аудитын дүгнэлтэд холбогдох нотлох зүйлс, бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитыг Үндэсний аудитын газрын 2 дугаар хэлтсийн дарга О.Мэндбаяр удирдаж, аудитор Г.Нямдорж, А.Сүхбаатар нар 2006 оны 1 дүгээр сард хийж гүйцэтгэв.

Аудитын дүн

Авсан болон төлсөн зээлийн тооцоо, түүнийг нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Буянт-Ухаа олон улсын нисэх буудал /ОУНБ/-ын өргөтгөлд зориулан Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банк /АХБ/-наас жилийн 1 хувийн үйлчилгээний хураамжтай, 30 жилийн хугацаатай 25745.0 мянган зээлжих тусгай эрх /ЗТЭ/-тэй тэнцэх валютын зээл авахаар 1993 оны 12 дугаар сарын 21-ний өдөр, Агаарын навигацыг хөгжүүлэхэд зориулан 15410.0 мянган ЗТЭ-тэй тэнцэх валютын зээл авахаар 1995 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр зээлийн хэлэлцээрүүд байгуулсан байна.

Монгол банк 1993, 1997 онд дээрх төслийн хэрэгжүүлэгч байгууллага Иргэний нисэхийн ерөнхий газар /ИНЕГ/-тай үндсэн зээлийг 1999 оноос эхлэн 20 жилийн хугацаанд жилийн 6.5 хувийн хүүтэй төлөх нөхцөлөөр дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулан, дээрх зээлийг олгож, 2001 онд эдгээр гэрээний дамжуулан зээлдүүлэгч нь Санхүү, эдийн засгийн яам /СЭЗЯ/ байхаар шинэчилжээ.

Авсан зээлийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал:

ИНЕГ төслийн хүрээнд хийгдсэн ажил, нийлүүлэгдсэн техник, тоног төхөөрөмжийн баримтыг үндэслэн хөрөнгийг зохих дансны орлогод авч, тухайн үеийн Монгол банкны валютын ханшийг үндэслэн тооцсон дүнгээр банкны урт хугацаатай зээлийн 3100-3701 тоот дансанд бүртгэсэн байна.

Буянт-Ухаа ОУНБ-ын өргөтгөлийн төсөлд авсан 25745.0 мянган ЗТЭ-тэй тэнцэх 35500.2 сая төгрөгийн зээлийг 1993 оноос 1999 оны 4 дүгээр сар хүртэл, Агаарын навигацыг хөгжүүлэх төсөлд авсан 15410.0 мянган ЗТЭ-тэй тэнцэх 20666.5 сая төгрөгийн зээлийг 1996 оноос 2001 он хүртэл хуримтлуулан бүртгэжээ.

2006 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар Буянт-Ухаа ОУНБ-ын өргөтгөлийн төслийн зээлийн үлдэгдэл 14581.0 мянган ЗТЭ-тэй тэнцэх 25542.4 сая төгрөг, Агаарын навигацыг хөгжүүлэх төслийн зээлийн үлдэгдэл 9354.2 мянган ЗТЭ-тэй тэнцэх 17839,5 сая төгрөг байна.

/Зээл авсан, төлсөн байдал, валютын ханшийн зөрүүг тооцож тусгасан дэлгэрэнгүй судалгааг хавсралт-1-д харуулав./

Төлсөн зээлийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал:

Аудитын дүн

ИНЕГ 1993, 1997 онд Монгол банктай, 2001 онд ИНЕГ СЭЗЯ-тай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу зээл, зээлийн хүүг төлж байна.

ИНЕГ-аас Монгол банкинд 1996 он хүртэл 1140.9 сая төгрөгийн зээлийн хүүг төлжээ.

Сангийн яам 1998-2000 онд ИНЕГ-аас төвлөрүүлсэн навигацын орлогыг төлөх зээл, зээлийн хүүгийн төлбөрт тооцож, харилцан зөвшөөрсөн протокол үйлдсэн байна.

Үүнийг 2001 онд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээнд нарийвчлан тусгаж, уг гэрээний 4.5 дугаар зүйлд “СЭЗЯ-нд төлөх зээл, зээлийн хүүгийн төлбөрийн эх үүсвэр нь АХБ-тай хийсэн гэрээний дагуу навигацын орлого ба Буянт-Ухаа ОУНБ-ын орлого мөн болно. Навигацын орлого нь Улсын төсөвт төвлөрч байгаа нөхцөлд уг Зээлийн гэрээний 4.1 ба 4.2 заалтууд хүчингүй болж, үндсэн төлбөр болон зээлийн хүүг СЭЗЯ дангаараа хариуцна” гэж заажээ.

Энэ заалтын дагуу ИНЕГ 1998-2005 онд 90935.0 сая төгрөгийн навигацын орлогыг улсын төсөвт төвлөрүүлсний 26510.4 сая төгрөгийг үндсэн зээлийн, 29155.2 сая төгрөгийг зээлийн хүүгийн, 35269.4 сая төгрөгийг татварын бус орлогын төлөлтөөр тооцож дараахь байдлаар нягтлан бодох бүртгэлд тусгажээ.

Гүйлгээний утга	Мөнгөн дүн \сая.төг\	Харьцсан данс	
		ДТ	КТ
Буянт-Ухаа ОУНБ-ын зээлийн хүү	19025.6	1200-1307 Системийн байгууллагын авлага	3100-3222 Орлогын татварын өглөг
Үндсэн зээл	26510.4	3100-3701 Банкны урт хугацаат зээл	3100-3222 Орлогын татварын өглөг
Агаарын навигацын зээлийн хүү	10129.6	8102-0000 Урт хугацаат зээлийн хүү	3100-3222 Орлогын татварын өглөг
Навигацын орлого	35269.4	8713-0000 Орлогын татварын зардал	3100-3222 Орлогын татварын өглөг
ДҮН	90935.0		

ИНЕГ төсөвт төвлөрүүлэх навигацын орлогыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа урт хугацааны зээлийн өглөг дансанд тусгагдсан зээлийн өрөөс тухайн жилд төлөх

Аудитын дүн

үндсэн зээлийн хэмжээгээр бууруулж, зээлийн хүүг зээлийн хүүгийн зардал, үлдэх орлогыг орлогын татварын зардлын дансанд бичсэн байна.

Буянт-Ухаа ОУНБ-ын өргөтгөлийн төсөлд авсан зээлээс үндсэн зээлийн төлбөрт 11164.0 мянган ЗТЭ-тэй тэнцэх 15460,7 сая төгрөг, зээлийн хүүд 19025,6 сая төгрөг, Агаарын навигацыг хөгжүүлэх төсөлд авсан зээлээс үндсэн зээлийн төлбөрт 6055.8 мянган ЗТЭ-тэй тэнцэх 11049.7 сая төгрөг, зээлийн хүүд 10129.5 сая төгрөгийг төлжээ. /Авсан зээл болон зээлийн үлдэгдлийн хэмжээг “Авсан зээлийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал” дэд бүлгээс үзнэ үү/

ИНЕГ дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 1998-2005 онд улсын төсөвт төвлөрүүлэх навигацийн орлого төлөлтийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдлыг харуулбал:

Гүйлгээний утга	Мөнгөн дүн (\сая.төг\)	Харьцсан дансад	
		ДТ	КТ
Навигацийн орлогыг төвлөрүүлэв	90935.0	3100-3222 Орлогын татварын өглөг	1133-0000 ХХБ 1131-0000 ХХБ 1140-0000 Төрийн сан дахь харилцах

/ИНЕГ-аас улсын төсөвт төвлөрүүлсэн навигацийн орлогын тооцоог хавсралт-2-т харуулав./

Сангийн яам зээл төлөлтийг тооцсон байдал:

Сангийн яам ИНЕГ-тай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу улсын төсөвт төвлөрүүлэх навигацийн орлогыг төсвийн орлогын 1998-2005 онуудын төлөвлөгөөнд тусган 90935.0 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

СЭЗ-ийн сайдын 2001 оны 121 дүгээр тушаалаар баталсан “Олон улсын байгууллага, гадаад улсаас Монгол Улсын Засгийн газрын авсан зээлийн хүрээнд дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийг тусгай дансанд төвлөрүүлэх, зарцуулах журам”-ын 2.1-д “Олон улсын санхүүгийн байгууллага, гадаад улсаас Монгол Улсын Засгийн газрын авсан зээлийн хүрээнд дотоодын аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийг зөвхөн

Аудитын дүн

тусгай дансанд төвлөрүүлж байх талаар зээл ашиглагчтай байгуулах дамжуулан зээлдүүлэх гэрээнд заавал тусгаж байна” гэж заасны дагуу ИНЕГ-ын 55565.6 сая төгрөгийн зээл, зээлийн хүүг Сангийн яамны Төсвийн орлогын хэлтэс дамжуулан зээлдүүлэх тусгай дансанд төвлөрүүлэх арга хэмжээ аваагүй байна.

Тус яамны Өрийн удирдлагын хэлтэс 2001 оноос хойш зээл, зээлийн хүүгийн төлөлтийн тооцоог дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу нийлж, зээлийн өрийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Дамжуулан зээлдүүлэх гэрээ болон дээрх журмын дагуу эдгээр зээл, зээлийн хүүд төлөх төлбөр дамжуулан зээлдүүлэх дансанд төвлөрөөгүй байхад 1999-2005 онд Сангийн яам зээлийн төлбөрт 1557.5 мянган ам.доллар буюу 1864,1 сая төгрөг, зээлийн хүүгийн төлбөрт 3655,0 мянган ам.доллар буюу 4145,3 сая төгрөг, нийтдээ 6.0 тэрбум төгрөг төлжээ.

Сангийн яам АХБ-наас авсан зээлийг төсөл хэрэгжсэн ИНЕГ-т дамжуулан зээлдүүлснээс 1998-2005 онд 84,9 тэрбум төгрөгийн нэмэгдэл орлогыг улсын төсөвт оруулжээ.

Зээл төлөх орлого бүрдүүлсэн байдал

Төслүүд хэрэгжихээс өмнө 1995 онд навигацын орлого 2.9 тэрбум төгрөг, Буянт-Ухаа ОУНБ-ын орлого 139.2 сая төгрөг байсан бол 2005 онд навигацын орлого 39.7 тэрбум төгрөг, нисэх буудлын орлого 6.0 тэрбум төгрөгт хүрч, 2003 онд “SARS” өвчин гарсантай холбогдон нисэх буудлын орлогын төлөвлөгөө тасарснаас бусад тохиолдолд жил бүр орлогын төлөвлөгөө давж биелжээ.

Орлогын төлөвлөгөөний биелэлт

Он	Навигацийн орлого		Буянт ухаа ОУНБ-ийн орлого	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1999	14971.3	21891.2	2316.7	2813.9
2000	21264.4	22970.4	2292.4	2730.8
2001	15916.7	25693.8	2511.1	3033.8
2002	23706.4	24888.8	3575.3	5089.1
2003	24760.5	26213.0	4183.5	3938.5
2004	24851.9	35389.4	4321.3	5314.9
2005	32982.8	39667.2	4323.5	6524.5

2005 онд нисэх буудлын зорчигчдын хураамжийн

орлого 2.7 тэрбум төгрөгт хүрч 1999 оноос 2.9 дахин, буулт, хөөрөлтийн орлого 2.4 тэрбум төгрөгт хүрч 2 дахин нэмэгдсэн нь Буянт-Ухаа ОУНБ-ын орлогын өсөлтийн дийлэнх хувийг эзэлж байна.

Агаарын хөлгийн даацаас хамааран Монгол улсын агаарын зайд нислэг үйлдсэн алслалын 100 км тутамд олон улсын нислэг үйлдсэн авиакомпаниудад гадаадынхаас 10-64 ам.доллар, дотоодынхоос 4.5-63.8 мянган төгрөг, орон нутгийн шугамд нислэг үйлдсэн гадаад, дотоодын авиакомпаниудаас 0.6-11.0 мянган төгрөгийн үйлчилгээний хөлс авч навигацгийн орлогыг бүрдүүлж иржээ.

ИНЕГ 2005 оны эцэст зээл, зээлийн хүүгийн эх үүсвэрт ашиглах навигацын орлогыг 29.5 тэрбум төгрөг, Буянт-Ухаа нисэх буудлын орлогыг 5.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

НҮБ-ийн төрөлжсөн байгууллага болох ИКАО-гийн ДОС-908/5 дугаар бичиг баримтад “Аэронавигацын орлогыг агаарын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган удирдахад зарцуулна”, Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлд “Иргэний нисэхийн үйлчилгээний орлогыг хууль тогтоомжийн хүрээнд нислэгийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд зориулан захиран зарцуулах”, төслийн хэрэгжилттэй холбогдон АХБ-ны ажлын хэсэг Монгол Улсын Засгийн газартай хийсэн харилцан ойлголцох меморандумд “Засгийн газар ИНЕГ-ын үйл ажиллагааны засвар үйлчилгээний зардал, өр төлбөр төлөх ба иргэний нисэхийн зориулалттай хөрөнгө оруулалт хийх, сэлбэг тоног төхөөрөмжийн болон бусад зардлуудыг санхүүжүүлсний дараа илүү гарсан орлогыг ногдол ашиг болгон авдаг байх” гэж заажээ.

Гэтэл жил бүр Монгол Улсын төвлөрсөн төсвийн тухай хуулиар навигац /өнгөрөлт/-ын орлогыг улсын төвлөрсөн төсөвт татварын бус орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээр баталж байна.

ИНЕГ-аас хэрэгжүүлсэн төслийн үр дүн

Манай орны нутаг дээгүүр дамжин өнгөрөх, буух гадаад орнуудын нислэгийн тоо нэмэгдсэнээр нислэгийн аюулгүй байдлыг хангах, үйлчилгээг сайжруулах шаардлага нэмэгдсэний дагуу Буянт-Ухаа ОУНБ-ыг өргөтгөх, Агаарын навигацыг хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлжээ.

Буянт-Ухаа ОУНБ-ыг өргөтгөх төслөөр нисэх буудлын

үйлчилгээг орчин үеийн нөхцөлд нийцүүлэх, Агаарын навигацыг хөгжүүлэх төслөөр төв, орон нутгийн 22 цэгт сансрын холбоогоор дамжих хэт богино долгионы холбоо тавих, дуун болон өгөгдөл дамжуулах сүлжээ бий болгох, навигац, логацийн системийг орчин үеийн найдвартай тоноглолоор шинэчлэн нислэгийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилт тавьжээ.

1993-1999 онд хэрэгжсэн Буянт-Ухаа ОУНБ-ын өргөтгөлийн төслийн хүрээнд:

- онгоц хөөрч-буух хатуу хучилттай зурвасыг засварлан шинээр хучилт хийсэн
- зурвасын уртыг 3100 м, өргөнийг 60 м болгож нэмэгдүүлсэн
- үндсэн болон явгалах зурвасын гэрэл дохиоллын системийг шинэчилсэн
- нисэх буудлын барилгад өргөтгөл хийж, инженерийн байгууламж, техник тоног төхөөрөмжийн 85-90 хувийг шинэчилсэн
- агаарын хөлгүүдэд техникийн засвар үйлчилгээ хийх ангарын барилга, ачаа тээврийн цогцолбор, автомашины үйлчилгээний граж, нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгыг барьсан байна.

1996-2000 онд Агаарын навигацыг хөгжүүлэх төслийн хүрээнд:

- навигацын тоног төхөөрөмж холбооны хэрэгслийг суурилуулан ашиглалтад оруулсан
- Чойбалсангийн нисэх буудлыг өргөтгөсөн
- Гэрэл, суултын тоног төхөөрөмжийг шинэчилсэн
- Тээврийн хэрэгсэл, нисэх талбайн тоног төхөөрөмжүүд бэлтгэсэн байна.

Зөвлөх болон банкны үйлчилгээнд 3.6 сая ам.доллар, Монголын талаас гэрээний дагуу тоног төхөөрөмжийн гааль худалдааны татвар, тээвэр, сургалт, засварын зардалд 2.5 сая ам.доллар зарцуулжээ. */Төслийн хүрээнд хийгдсэн ажлын жагсаалтыг хавсралт-3-т харуулав./*

ИНЕГ 1996 онд агаарын 2 замаар олон улсын нислэгийн 15.6 мянган өнгөрөлтийг үйлчилж байсан бол Агаарын навигацыг хөгжүүлэх төсөл хэрэгжсэнээр агаарын зам 6 болж нэмэгдэн 2005 онд 47.1 мянган өнгөрөлтийг үйлчилжээ.

Аудитын дүн

Буянт-Ухаа ОУНБ-ын өргөтгөлийн төсөл хэрэгжсэнээр зорчигчдод үйлчлэх хүчин чадлыг цагт 1200 болгон нэмэгдүүлж, олон улсын буулт, хөөрөлтийн тоо 1993 онд 100 байсан бол 2005 онд 3419, зорчигчдын тоо 1995 онд 136.6 мянган хүн байсан бол 2005 онд 442.5 мянган хүн болж өсчээ.

Аудитын дүн, цуглуулсан нотлох зүйлст үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

1. Буянт-Ухаа нисэх буудлыг өргөтгөх, Агаарын навигацыг хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэхээр АХБ-аас авсан болон төлсөн зээлийг ИНЕГ нягтлан бодох бүртгэлд зохих ёсоор тусгаж, дамжуулан зээлдүүлэх гэрээний үүргийг биелүүлж байна.
2. Сангийн яам улсын төсвийн навигацын орлогоос дамжуулан зээлдүүлэх тусгай дансанд 55.6 тэрбум төгрөгийн зээл, зээлийн хүүг төвлөрүүлээгүй байна.
3. ИНЕГ Буянт-Ухаа нисэх буудлыг өргөтгөх, Агаарын навигацыг хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлснээр 56.2 тэрбум төгрөгийн барилга байгууламж, техник, тоног төхөөрөмж ашиглалтад оруулж, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэсэн нь олон улсын иргэний нисэхийн стандартын дагуу үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлсэн байна.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

210134 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
Буянт-Ухаа Утас: 98-20-64, Факс: 98-21-02

2006.02.23 № 1/94
танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАРТ**

Сангийн яам болон Иргэний нисэхийн ерөнхий газрын хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх 1256 MON (SE), 1370 MON (SF) төслийн гэрээний биелэлтэнд хийсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна.



ДАРГА

М.ДАГВА



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-02-47, <http://www.mof.gov.mn>

Үндэсний Аудитын Газарт

2006.03.09 № 5-74/867

танай _____-ны № _____-т

Санал өгөх тухай

Танай газраас Иргэний Нисэхийн Ерөнхий Газар, Санхүү, эдийн засгийн яамны хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх 1256 MON (SF), 1370 MON(SF) гэрээний биелэлтэнд хийсэн Үндэсний аудитын газрын тайлангийн төсөлтэй танилцлаа. Улсын төсөв болон гадаадын зээлийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийн талаар хийсэн энэхүү шалгалт нь зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулах, зээлийн үр ашгийг нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна. Шалгалтын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Иргэний нисэхийн ерөнхий газар бол аж ахуйн нэгж бус, Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг болно. ИНЕГ нь үйл ажиллагааны орлогоор санхүүждэг бөгөөд тухайн жилийн орлого, зарлагын төсвийг Сангийн сайд, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд хамтран баталдаг. "Засгийн Газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай" Монгол Улсын хуулийн 14.4 дахь заалтын дагуу ИНЕГ-ын тухайн жилийн орлогоос батлагдсан зардлыг нөхөж, төсөвт төлөх төлбөрийн тооцоо буюу тухайн жилийн "Төсвийн тухай хууль"-иар батлагдсан дүнг төлсний дараа үлдэх орлогын зохих хэсгийг тухайн агентлагийн материаллаг баазыг бэхжүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах зориулалтаар түүнд үлдээж, бусдыг нь мөн л улсын төсөвт төвлөрүүлэхээр заасан. Мөн тухайн агентлагийн мэдэлд үлдэх орлогын хувь хэмжээг Сангийн сайд, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд хамтран тогтоохоор заасан тул аудитын дүгнэлтийн 9 дүгээр хуудасны холбогдох хэсэгт тусгуулах саналтай байна.

2. АХБ, Монгол Улсын Засгийн газрын хооронд 1995 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр байгуулсан Зээлийн хэлэлцээрийн дагуу дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийн эх үүсвэр нь навигацын орлого байхаар тусгагдсан тул 1999-2001 онд тус яам ИНЕГ-тай дамжуулан зээлдүүлэх гэрээний биелэлтийг дүгнэж, ИНЕГ-аас тухайн жилд төвлөрүүлсэн навигацын орлогоос зээлийн төлбөрийг суутган тооцож, протокол үйлдэн тооцоог тухай бүр нь баталгаажуулж иржээ.

68 0998

Үүнийг 2001 оны 5 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан 1256 MON(SF), 1370 MON(SF) дугаарт гэрээнд нарийвчлан тусгаж, гэрээний 4.5 дахь заалтад "СЭЗЯ-нд төлөх зээл, зээлийн хүүгийн төлбөрийн эх үүсвэр нь АХБ-тай хийсэн гэрээний дагуу Навигацын орлого ба Буянт-Ухаа ОУНБуудлын орлого мөн болно. Навигацын орлого нь улсын төсөвт төвлөрч байгаа нөхцөлд уг зээлийн гэрээний 4.1, 4.2 заалтууд хүчингүй болж, үндсэн төлбөр болон зээлийн хүүг СЭЗЯ дангаараа хариуцна" гэж зааж, гэрээг шинэчлэн байгуулжээ.

Энэ заалтын дагуу ИНЕГ "Төсвийн тухай хууль"-иар батлагдсан тухайн жилийн навигацын орлогыг улсын төсөвт төвлөрүүлж, уг орлогоор тухайн жилд төлөх ёстой дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлсөнд тооцож, тайлан тэнцэлдээ өглөгөө хорогдуулж ирсэн.

Сангийн яам дээрх заалтын дагуу тухайн жилд төлөх ИНЕГ-ын навигацын орлогын дүнг улсын төсвийн орлого талд суулгаж, АХБ-тай хийсэн Зээлийн хэлэлцээрийн дагуу тухайн жилд төлөх дамжуулан зээлдүүлэх зээлийн төлбөрийн дүнг улсын төсвийн зардал талд суулган тооцож иржээ. Энэ талаар аудитын тайланд тусгуулах саналтай байна.

3. Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан "Олон улсын байгууллага, гадаад улсаас Монгол Улсын Засгийн Газрын авсан зээлийн хүрээнд дотоодын аж ахуйн нэгж байгууллагад дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийг тусгай дансанд төвлөрүүлэх, зарцуулах журам"-д заасны дагуу дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн тусгай дансанд төвлөрүүлэхээр заасан. Энэ заалтын дагуу Сангийн яам тусгай дансанд дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийг төвлөрүүлээгүй гэсэн аудитын дүгнэлтийг хүлээн авч, улсын 2006 оны төсөвт тодотгол хийх гэж байгаатай холбогдуулан цаашид навигацын орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхдээ дамжуулан зээлдүүлэх зээлийн төлбөрийг хэрхэн суутган тооцох талаар чиглэл өгсөн заалтыг аудитын тайланд тусгах, тухайлбал ИНЕГ-ын навигацын орлогоос төлбөрийн хуваарийн дагуу тухайн жилд төлөх ёстой зээлийн төлбөрийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн "900 000 711" тоот дансанд төвлөрүүлж, үүнээс илүү гарсан хэсгийг улсын нэгдсэн төсвийн орлого талд тусгаж байхаар тогтох, ИНЕГ-ын 2006 оны төсвийн тодотголд "2006 онд дамжуулан зээлдүүлэх гэрээний төлбөрийн хуваарийн дагуу төлөх ёстой үндсэн төлбөрийн 4,8 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрийн 2,6 тэрбум төгрөг, нийт 7,4 тэрбум төгрөгийг Сангийн яамны дамжуулан зээлдүүлсэн зээлийн "900 000 711" тоот дансанд төвлөрүүлж, үүнээс илүү гарсан хэсгийг улсын төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлэх"

Холбогдох байгууллагын санал

үүргийг Сангийн яам, ИНЕГ-т зөвлөмж болгож гаргах шаардлагатайг анхаарч авч үзэхийг хүсье.



ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ч.ХҮРЭЛБААТАР

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна:

Сангийн сайд Н.Баяртсайханд:

1. Буянт-Ухаа нисэх буудлыг өргөтгөх, Агаарын навигацыг хөгжүүлэх зориулалтаар ИНЕГ-ын авсан зээлийн төлөлтөд хяналт тавьж төлбөрийн тооцоог жил бүр хийж байх
2. Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 121 дүгээр тушаалаар баталсан “Олон улсын байгууллага, гадаад улсаас Монгол Улсын Засгийн газар авсан зээлийн хүрээнд дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийг тусгай дансанд төвлөрүүлэх, зарцуулах журам”-ыг хэрэгжүүлж ажиллах
3. Навигацын орлогыг улсын төсөвт төвлөрүүлж байгаа хэлбэрийг олон улсын баримт бичиг, Монгол Улсын хуульд нийцүүлэх

ИНЕГ-ын дарга М.Дагвад:

1. Төслийн хүрээнд нийлүүлсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

ХЭЛТСИЙН ДАРГА

О.МЭНДБАЯР